



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/532.

Есөнбулаг

“Алтай-түншлэл-2023” үзэсгэлэн
худалдаа зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар тариалан, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, тэдний үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүнийг зах зээлд таниулан сурталчлах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Алтай түншлэл-2023” үзэсгэлэн худалдааг 10 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд Алтай хотод зохион байгуулсугай.

2.Үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталж, бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөг гарган, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэж, чанартай зохион байгуулж, үр дүнг танилцуулж, нийтэд мэдээлж ажиллахыг ажлын хэсэг (Т.Сүхбаатар)-т үүрэг болгосугай.

3.Газар тариалан, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг үзэсгэлэн худалдаанд өргөнөөр оролцуулахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны
29 дугаар сарын 29-ны өдрийн 1150 дугаар
захирамжийн хавсралт

**"УРГАЦЫН БАЯР-2023" ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Т.Сүхбаатар	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд:	
Т.Эрхэмбаяр	(Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төвийн захирал)
Ж.Уранчимэг	(Биеийн тамир, спортын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Т.Мөнхнасан	(Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга)
Г.Төгсбилэг	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын ургамал хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч)
Э.Танхилмаа	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын хүнсний чанар стандартын хяналтын улсын байцаагч)
Л.Сувд-Эрдэнэ	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын хүнсний чанар стандартын хяналтын улсын байцаагч)
П.Мөнхзаяа	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)
А.Алтанхуяг	(Есөнбулаг сумын Засаг дарга)
Б.Оюунцэцэг	(Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга: Г.Энхбаяр	Сумын Засаг дарга нар (Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга)

__оОо__